

Sikafloor®-263 SL

2 бүрэлдэхүүнт өөрөө тархан тэгширдэг систем

Бүтээгдэхүүний тодорхойлолт

Sikafloor® -263 SL нь 2 бүрэлдэхүүнт өөрөө тэгширдэг, эпоксид резин суурьтай олон үйлдэлт холбогч бүтээгдэхүүн юм.

Хэрэглээ:

- Энгийнээс дунд түвшний ачаалал бүхий агуулах, хурлын танхим, засварын цех, автозогсоол, ачаа буулгах газар зэрэг олон төрлийн орчны бетон болон цементэн суурьтай тэгшилгээнд өөрөө тэгшрэх давхрага зориулалтаар ашиглаж боломжтой.
- Ундаа үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэл, засварын ангар г.м нойтон ажиллагаатай талбайд хэрэглэхэд тохиромжтой хучих систем юм.

Бүтээгдэхүүний шинж чанар ба давуу талууд

- Дүүргэх чадвар маш өндөр
- Химийн болон механик эсэргүүцэл сайтай
- Хэрэглэхэд хялбар
- Эдийн засгийн үр өгөөжтэй
- Шингэнд тэсвэртэй
- Уусгагч агуулаагүй
- Бөх бат, хагас гялгар гадаргуу
- Хальтрахгүй гадаргуу үүсгэх боломжтой

Зөвшөөрөл / Стандарт

GB/T 22374-2008 нийцсэн суурь түрхлэгийн сертификаттай

Бүтээгдэхүүний үзүүлэлт

Хэлбэр / Төлөв

Харагдах байдал / Өнгө

А хэсэг – Резин: өнгөт шингэн
Б хэсэг – Хатууруулагч: тунгалаг шингэн

Стандарт өнгүүд: RAL 1001, 1023, 5012, 6021, 7001, 7030, 7032, 7035, 7040, 7042, 7044, 7047

Захиалгын дагуу бусад өнгөнүүдийг үйлдвэрлэх боломжтой

Тод өнгө, жишээ нь шар болон улбар шар өнгөнд кварцын элсээр суурь дэрлэж өгсөн тохиолдолд өнгөний хэлбэлзэл үүсэх боломжтой байдаг. Түүнчлэн нарны шууд тусгалаас үүдэн өнгөний хэлбэлзэл үүсэх боломжтой байдаг. Гэвч өнгөний өөрчлөлт нь бүтээгдэхүүний гүйцэтгэлийн үр дүн болон зориулалтад ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй

Sika баглаа боодол

А хэсэг : 20,54 кг

Б хэсэг: 5,46 кг

Хадгалалт

Хадгалах нөхцөл / Хугацаа

Сав баглаа боодол онгойж, гэмтээгээгүй тохиолдолд үйлдвэрлэсэн өдрөөс 24 сарын хугацаанд хуурай сэрүүн, +5°C + 30°C орчинд хадгална.

Техникийн үзүүлэлт

Химийн найрлага

Эпоксид

Нягт (+23°C орчинд)

А хэсэг: ~ 1,60 кг/л
Б хэсэг: ~ 1,00 кг/л (GB 6750-д нийцсэн)
А+Б хольц: ~ 1,4 кг/л
Дүүргэсэн резин 1 : 0,7: ~ 1,75 кг/л

Хуурай хэсгийн Агууламж

~ 100% (эзлэхүүний) / ~ 100% (жингийн)

Механик / Физик шинж чанар

Шахалтын бат бэх

Резин: ~ 60 кг/см² (+23°C орчинд, 28 хоногийн дараа)
(GB /T 17671-д нийцсэн)

Гулзайлтын бат бэх

Резин: ~ 30 кг/см² (+23°C орчинд, 28 хоногийн дараа)
(GB /T 17671-д нийцсэн)

Барьцалтын бат бэх

> 1,5 кг/см² (бетоны гэмтэл) (JC/T 907)

Эргийн хатууралт (Shore D Hardness)

76 (+23°C орчинд, 7 хоногийн дараа) (GB/T 2411)

Эсэргүүцэл

Дулааны эсэргүүцэл

Гадны нөлөөлөл *	Хуурай халаалт
Урх хугацаанд	+50° C
Хамгийн ихдээ 7 хоног үргэлжлэх богино хугацаанд	+80° C
Хамгийн ихдээ 12 цаг үргэлжлэх богино хугацаанд	+100° C

Богино хугацааны +80°C халуунтай тогтмол бус чийгтэй/нойтон халаалт байх боломжтой (жишээ нь халуун ууран цэвэрлэгээ г.м)

* Химийн болон физик хавсарсан нөлөөнд 3 – 4 мм-ийн зузаантай хийгдэх Sikafloor® системтэй хослуулан хэрэглэх ёстой.

Системийн мэдээлэл

Системийн бүтэц

Өөрөө тэгширдэг систем 1,5 – 3,0 мм:

Суурь түрхлэг: 1 x Sikafloor -161

Хучилтын давхрага: 1 x Sikafloor -263 SL + кварцын элс (Sikadur 505Q)

Хучих систем, ойролцоогоор 4 мм:

Суурь түрхлэг: 1 x Sikafloor -161

Тулгуур түрхлэг: 1 x Sikafloor -263 SL + кварцын элс (Sikadur 505Q)

Хучих: кварцын элс (Sikadur 505Q) их хэмжээтэйгээр хучиж өгөх

Битүүмжлэх түрхлэг: 1 x Sikafloor -264

Санамж: Гадны нөлөө багатай болон энгийн шингээгч бетон гадаргууд Sikafloor® -161 суурь түрхлэг түрхэх шаардлагатай.

Хэрэглээний мэдээлэл

Зарцуулалт

Түрхлэгийн систем	Бүтээгдэхүүн	Зарцуулалт
Суурь түрхлэг	Sikafloor® -161	0.35 - 0.55 кг/м ²
Тэгшилгээ (туслах чанарын):	Sikafloor® -161 тэгшилгээний шавардлага	Sikafloor® -161 -ийн бүтээгдэхүүний техникийн зааварчилгааны дауу
Өөрөө тэгшрэх, элэгдэлд тэсвэртэй давхрага (хучилтын зузаан ~ 1.5 - 3.0мм):	жингийн хэмжээний 1 Sikafloor®-263 SL + жингийн хэмжээний 0.7 кварцын элс (Sikadur 505Q)	1.75 кг/м ² /мм хольц (1 мм зузаантай) Дүүргэгчийн хэмжээ нь температур болон дүүргэгчийн хэмжээнээс хамаарна
Хучих систем (хучилтын зузаан ~ 4.0мм):	жингийн хэмжээний 1 Sikafloor®-263 SL + жингийн хэмжээний 1 кварцын элс (Sikadur 505Q) + хучих кварцын элс 0.4 - 0.7 мм + битүүмжлэх түрхлэг Sikafloor - 264	2.0 кг/м ² 2.0 кг/м ² ~ 4.0 кг/м ² ~ 0.7 кг/м ²

Анхаар: Дээрх үзүүлэлт нь онолын тооцоололд үндэслэгдсэн бөгөөд гадаргуун төрх, нүхжилт, тэгш бус байдал болон хаягдлын хэмжээ зэрэг нэмэлт зарцуулалтын хэмжээ тусгагдаагүй болно.

Өөрөө тэгшрэх системийн кварцын элсний хэмжээ нь орчны болон гадаргуун температурыг ойролцоогоор +23°C болон 2 мм-ийн зузаантай хийгдэнэ гэж тооцоолсон болно. Иймээс бодит байдал дээр тухайн төслийн температур болон зузаан их байх тусам резин хольц дахь кварцын элсний хэмжээ нэмэгдэх болно.

Гадаргуун чанар

Бетоны гадаргуу бат бэх байж хангалтай хэмжээний шахалтын бат бэхэд хүрч (хамгийн багадаа 25 кг/ см²), бетоныг үл эвдэх аргаар бат бэх тодорхойлоход хамгийн багадаа 1,5 кг/см² хүрсэн байх шаардлагатай.

Гадаргуу нь урвалд орж болзошгүй тос тосоол, арчилгааны түрхлэгүүд зэрэг бохирдлоос ангид цэвэр, хуурай байх хэрэгтэй.

Эргэлзээтэй тохиолдолд гадаргуу дээр урьдчилан тестлэж үзнэ үү.

Гадаргууг бэлдэх

Бетон, чулуу, шавардлага, өнгөлгөөний шавардлага:

Цахилгаан үлээгч болон зүсэгч багажын тусламжтайгаар механик аргаар гадаргуу дээрх гэмтэлтэй сул хэсгийг хуулан авч, урвалд орж болзошгүй түрхлэг, арчилгааны бүтээгдэхүүнүүд болон цементийн сүүг цэвэрлэж, гадаргуун өнгөн хэсгийг нээлттэй бүтэцтэй болгоно.

Бетоны сул хэсгүүдийг тайран авч гадаргуу дээрх барзайлт, нүхжилтийг ил гаргаж нээж өгнө.

Гадаргуун барзайлт, нүхжилтийг засч, тэгшилгээг хийхдээ зориулалтын Sikafloor®, SikaDur®, SikaGard® төрлийн бүтээгдэхүүнийг ашиглан засварлана.

Бетон болон өнгөлгөөний гадаргууд суурь түрхлэг болон тэгшилгээ хийж, гадаргууг жигд тэгш гадаргуу үүсгэнэ.

Тод өнгийн толбо бүхий талбайг зүлгүүрээр зүлгүүрдэж арилгана.

Бүтээгдэхүүнийг хэрэглэхээс өмнө гадаргуу дээр тоос шороог тоос сорогч болон шүүрээр бүрэн цэвэрлэсэн байна.

Хэрэглэх нөхцөлүүд /

Хязгаарлалтууд

Гадаргуун температур

хамгийн багадаа +10°C/ хамгийн ихдээ +30°C

Орчны температур

хамгийн багадаа +10°C/ хамгийн ихдээ +30°C

Гадаргуун чийгшлийн Хэмжээ

≤ 4% байх ёстойг анхаарна уу.

Тестлэх аргачлал: Sika® -Tramex метр, CM-хэмжигч

ASTM стандартын дагуу чийгшлийн хэмжээ өсөн нэмэгдэхгүй (полиэтилен хучлага).

Харьцангуй чийгшлийн Хэмжээ

хамгийн ихдээ 80%

Шүүдрийн цэг

Конденсаци үүсэхээс сэргийл.

Гадаргуу дээр конденсаци үүсэхээс сэргийлж, гадаргуу болон бэхжээгүй шал хамгийн багадаа шүүдрийн цэгээс дээс 3°C байх шаардлагатай.

Хэрэглэх заавар

Холих

А хэсэг : Б хэсэг = 79 : 21 (жингийн)

Холих хугацаа

А хэсгийг эхлээд механикаар хольж өгнө. Дараа нь дээрээс нь Б хэсгийг бүгдийг нь хийгээд ойролцоогоор 2 минутын турш нэгэн жигд хольц болтол сайтар хольж өгнө.

А ба Б хэсэг холигдсоны дараа дээрээс нь 0,1 – 0,3 мм-ийн кварцын элсийг хийж өгөх ба шаардлагатай тохиолдолд мөн Extender T-ийг нэмж хийгээд ойролцоогоор 2 минут хольцыг жигд болтол хольж өгнө.

Хольцыг төгс байдлыг хангахын тулд хольцоо өөр саванд хийгээд дахин хольж өгнө.

Холих явцдаа агаарын бөмбөлөг үүсэхээс болгоомжлох хэрэгтэй.

Холих багаж Sikafloor® -263 SL-ийг бага хурдтай цахилгаан хутгуур (минутад 300-400 эргэлттэй) болон бусад тохиромжит багаж ашиглан хутгаж өгнө.

Зуурмагыг бэлдэхдээ эргэлддэг тогоо, тэвш, хутгагч төрлийн хүчлэх үйлдэлээр ажилладаг холигч ашиглах хэрэгтэй. Чөлөөт уналтын холигч ашиглаж болохгүй

**Хэрэглэх заавар /
Багаж**

Бүтээгдэхүүнийг хэрэглэхээс өмнө гадаргуун чийгшил, харьцангуй чийгшилийн хэмжээ болон шүүдрийн цэгийг тодорхойлох хэрэгтэй.

Хэрэв pwb чийгшилийн хэмжээ нь $> 4\%$ байвал Sikafloor® EpoCem® -ийг богино хугацааны чийгшилийн хаалтын зорилгоор хэрэглэх боломжтой.

Тэгшилгээ:

Барзгар гадаргууг эхлээд тэгшилж өгнө. Үүний тулд Sikafloor® -161 тэгшилгээний шавардлагыг хэрэглэнэ (бүтээгдэхүүний техникийн зааварчилгаатай танилцана уу)

Цэвэрлэгээ

Ажил дууссаны дараа бүх багаж, тоног төхөөрөмжүүдээ хатахаас нь өмнө Thinner C цэвэрлэгчээр цэвэрлэх хэрэгтэй. Бэхжиж хатсан бүтээгдэхүүнийг зөвхөн механик аргаар л цэвэрлэх боломжтой.

Нээлттэй байх хугацаа

Температур	Хугацаа
+10°C	~ 50 минут
+20°C	~ 25 минут
+30°C	~ 15 минут

**Хүлээх / давхарлан
будах хугацаа**

Sikafloor® - 263SL бүтээгдэхүүнийг хэрэглэхээс өмнө Sikafloor® -161 бүтээгдэхүүнийг доорх хугацаагаар бэхжүүлж өгнө:

Гадаргуун температур	Хамгийн багадаа	Хамгийн ихдээ
+10°C	24 цаг	3 өдөр
+20°C	12 цаг	2 өдөр
+30°C	6 цаг	1 өдөр

Дээрх хугацаа нь ойролцоогоор тооцоолсон хугацаа бөгөөд орчны температур, харьцангуй чийгшилийн өөрчлөлтийн нөлөөгөөр зөрүүтэй үр дүн үзүүлэх боломжтой.

**Анхаарах зүйлс /
Боломжууд**

Sikafloor® -263 SL ууршилтын даралт өндөртэй гадаргуунд түрхэж болохгүй.

Суурь түрхлэгийг далдлаж болохгүй.

Шинэхэн түрхсэн Sikafloor® -263 SL –ийг хамгийн багадаа 24 цагийн турш ус, чийгнээс болон конденсац үүсэхээс хамгаалах хэрэгтэй.

Суурь түрхлэгийг гадаргуу дээр тогтонги уусгэн их хэмжээтэй хэрэглэж болохгүй.

Гадны нөлөө багатай болон энгийн шингээгч бетон гадаргууд
Sikafloor® -161 суурь түрхлэг түрхэх шаардлагатай.

Түрхлэгийг өнхрүүшдэх: Тэгш бус гадаргуу болон гадаргуу дээрх
бохирдол дээгүүр нимгэн битүүмжлэгч түрхлэг түрхэж болохгүй.
Иймээс гадаргуу болон түүний залгаа талбайг гүйцэтгэлийн өмнө
заавал сайтар цэвэрлэсэн байх шаардлагатай.

Багажууд:

Санал болгох багаж үйлдвэрлэгч:

PPW-Polyplan-Werkzeuge GmbH, Холбогдох утас: +49
40/5597260, www.polyplan.com

Үе давхрагыг тэгшлэх хадаастай нийвий:

Гадаргуун том хусуур No. 565, Шүдтэй хэрчигч No.25

Үе давхрагад дүрс үүсгэх хадаастай нийвий:

Нийвий No. 999, эсвэл цавуу тараагч No.777, Шүдтэй хэрчигч No.23

Урьдчилсан боловсруулалт шаардагдах барилгын залгаасуудыг
дараах гүйцэтгэлийг хийж өгнө:

- хөдөлгөөнгүй хагарал: SikaDur® болон Sikafloor эпоксидын
резинээр дүүргэн тэгшилж өгнө.

- идэвхтэй хагарал: тооцооллыг хийж шаардлагатай тохиолдолд уян
хатан полимер бүхий материалаар эмжээр үүсгэн түрхэж өгөх буюу
хөдөлгөөнт заагийг битүүмжлэх бүтээгдэхүүн хэрэглэж болно.

Хагарлын алдаатай үнэлгээ болон түүнээс үүдсэн засварын
алдаатай гүйцэтгэл нь түүний хэрэглээний хугацаа болон засварын
эдэлгээний хугацааг бууруулах нөлөө үзүүлнэ.

Sikafloor® -263 SL бүхий гадаргуун өнгө нэгэн жигд байлгахын тулд
үйлдвэрлэлийн нэг зуурмагын дугаартай бүтээгдэхүүнийг
хэрэглэхийг зөвлөж байна.

Бэхжилтийн мэдээлэл

Гүйцэтгэлийн дараа Хэрэглээнд бэлэн болох

Температур	Явган хөдөлгөөн	Хөнгөн хөдөлгөөн	Бүрэн бэхжих
+10°C	~ 30 цаг	~ 6 өдөр	~ 10 өдөр
+20°C	~ 24 цаг	~ 3 өдөр	~ 7 өдөр
+30°C	~ 16 цаг	~ 2 өдөр	~ 5 өдөр

Анхаар: Дээрх хугацаа нь ойролцоо тооцоолол бөгөөд орчны
температурын нөлөөллөөс шалтгаалан ялгаатай үзүүлэлт гаргах
боломжтой.

Аргачлал

Sikafloor® -263 SL бүтээгдэхүүний гүйцэтгэлийн дараа гадаргуу дээрх
илүүдэл бүтээгдэхүүнийг зайлуулан авах шаардлагатай бөгөөд
эргэлдэгч сэнс, автомат цэвэрлэгч, өндөр даралтад ус, угаалга, тоос
соруулах машин г.м цэвэрлэгээний аргачлалаар тогтмол цэвэрлэж байх
шаардлагатай.

Дүгнэлт

Энэхүү Техникийн зааварчилгаанд дурьдагдсан үзүүлэлтүүд бүгд
лабораторын туршилтанд үндэслэгдсэн болно. Бодит үзүүлэлтүүд
нь тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байж болохыг
анхаарна уу.

Дотоодын хязгаарлалт

Тухайн улс орны дотоодын хууль тогтоомжоос хамааран уг
бүтээгдэхүүний гүйцэтгэл ялгаатай хийгдэх боломжтой. Иймээс

манай Техникийн хэлтэст холбогдож зөвлөгөө авах боломжтой.

**Эрүүл ахуй, аюулгүй
Ажиллагааны мэдээлэл**

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны болон физик, хими, байгаль орчны бусад нарийн мэдээллүүд бүтээгдэхүүний Эрүүл ахуй, Аюулгүй ажиллагааны зааварчилгаанд тусгагдсан болно.

Хамгаалах хэрэгсэл

Бүтээгдэхүүний гүйцэтгэлийг уурхай, босоо ам г.м битүү орчинд хийх тохиолдолд шаардлага хангасан агааржуулалтын систем ажиллаж байх шаардлагатай. Гагнуур зэрэг ил гал үүсэх орчноос хол байх хэрэгтэй.

Үйлдвэрлэлийн эрүүл ахуйн аюулгүй ажиллагааны суурь зарчим болох хамгаалах хувцас, бээлий, нүдний шил г.м хувийн хамгаалах хэрэгслийг өмс. Ажлын завсарлага болон ажил дууссаны дараа бохир хувцасаа тайлж, гараа сайтар угаа.

Эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны талаарх дотоодын журам болон бүтээгдэхүүний савлагаан дээрх мэдээлэлтэй танилцаж, дагаж мөрдөн ажиллах шаардлагатай.

Чухал санамж

Бүтээгдэхүүний хаягдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу устгал хийх хэрэгтэй. Холбогдох мэргэжлийн байгууллагуудын зөвшөөрлийн дагуу бүрэн бэхэжсэн бүтээгдэхүүнийг ахуйн бохирдолтой хамт устгах боломжтой.

Хууль эрх зүйн мэдээлэл

Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг нөөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдэхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.

Sika (China) Ltd.
No. 28 Jingdong Road, Suzhou Industrial Park,
JiangSu, P.R. China
Postal Code: 215121
Tel: (86) 512 6273 2888
Fax: (86) 512 6287 7070

<http://chn.sika.com>

The Sika logo consists of the word "Sika" in a bold, italicized, sans-serif font, with a registered trademark symbol (®) to its right. The logo is set against a red triangular background.